



НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 06 сарын 11 өдөр

Дугаар А/312

Улаанбаатар хот

Дэмжих баг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.2, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалт, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/173, А/251, А/380 дугаар хамтарсан тушаал "Хамтарсан багийн ажиллах, үйл ажиллагааг санхүүжүүлэх журам", Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 102 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/333 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хороодын Хамтарсан багийн үйл ажиллагааг дэмжих, идэвхжүүлэх, салбар дундын зохицуулалтыг хангах, удирдлага зохион байгуулалтыг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнг хянах, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, гэр бүл, хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр зөвлөх бүхий мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх "Дэмжих баг"-ийг байгуулсугай.

2. Мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх "Дэмжих баг"-ийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч /Г.Нарангэрэл/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.ОДОНТУЯА

Баянгол дүүргийн Засаг даргын
2020 оны 06 дугаар сарын 11-ны өдрийн
11 дугаар захирамжийн хавсралт

312



ДЭМЖИХ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Багийн дарга:	Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсийн дарга
Гишүүд:	Баянгол дүүргийн Прокурорын газрын Дарга, Ерөнхий прокурор Баянгол дүүрэг дэх Цагдаагийн газрын дарга Баянгол дүүрэг дэх Цагдаагийн газрын Цагдаагийн нэгдүгээр хэлтсийн дарга Баянгол дүүрэг дэх Цагдаагийн газрын Цагдаагийн хоёрдугаар хэлтсийн дарга Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Баянгол дүүргийн Хөдөлмөр, нийгмийн халамжийн хэлтсийн дарга Баянгол дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төвийн дарга Баянгол дүүргийн Боловсролын хэлтсийн дарга Баянгол дүүргийн Хүүхэд, залуучуудын соёлын ордон ОНӨТҮГ-ын дарга